

Түүхэн домог хийгээд баатарлаг туулийн харьцаа

Баатарлаг туулийн түүхэн шинжийг судлах асуудал бол баатарлаг туулийн уг сурвалж эх үүсэлтэй шууд холбогдох томоохон онолын асуудал болно. Баатарлаг тууль нь бусад стилийн бүтээлтэй нэгэн адил өөрийн уг сурвалж эх үүслийн зам мөртэй билээ. Бид баатарлаг туулийг хүн төрөлхтний нийгмийн эл түүхэн шат үед тохохгүй, зөвхөн тус биеийнх нь үүсэл бүрдлийн явцаас үзэхэд наад захын гурван шат үеийг өнгөрүүлсэн байна. Анхдугаар шат үе бол үнэн бодит түүх болно. Хэрвээ ийхүү үнэн бодитой түүхэн хэрэг явдлын урьдал нөхцөлгүй бол баатрын үүсэх бололцооо гэж үгүй юм. Иймээс үнэн бодитой түүх бол баатарлаг туулийн жинхэнэ уг сурвалж эх үүсэл болно. Хоёрдугаар шат үе бол түүхт домог буюу баатрын уламжлал яриа болно. Анхдугаар шат үе дэх үнэн бодит түүхт хэрэг явдал нь дөхөмхөн түүхэн домгийн хэлбэрээр ардын дунд тархан дэлгэрэхтэй зэрэг хоёрдугаар шат үедээ дэвшин орж, тэрчлэн эдгээр түүхт домог нь хэдий урт хугацаагаар уламжлагдах тутам түүхэн нарийлаг зүйлс нь төдий балархай болж агуулгаар улам баялаг болдог байна. Энэ нь эртний бусад урлагийн хэлбэр нэвтрэн орж ирсний шалтгаанаас болсон юм. Хожим нь эдгээр түүхт домог (баатрын уламжлал яриа) нь эртний шидэт үлгэр, домог яриа, магтаал гэх мэтийн балар урлаг болон баларлаг шашны зүйлсийг биедээ шингээж авсны улмаас хуудас хэмжээгээр урт, агуулга багтаамжаар баялаг “ерөнхийлсөн урлаг”-ийн шинж бүхий баатарлаг туулийн үүслийн шат үе болно. Энэ шат үед хүрч ирэхэд зарим үнэн бодит түүхэн шинж (жишээлбэл, хүний нэр, цаг үе, газар орон) нь балархай болох буюу бүрмөсөн алга болж зөвхөн гол гол үндсэн үйл явдал л үлддэг байна.

Баатарлаг тууль нь ийхүү түүх-түүхт домог (баатрын уламжлал яриа) - баатарлаг туулийн бүрэлдэл гэх гурван шат үеийг дамжиж үүсч бүрэлдсэн байдаг. Өнгөрсөнд тууль судлалынхан баатарлаг туулийг эртний шидэт үлгэр, домог яриа, ерөөл магтаал, дуу шүлэг зэрэг балар урлагийн суурь дээр буй болж үүслээ гэдэг нотлолт дүгнэлт нь хожмын

маш олон тууль судлагч нөхдийн бараг заншсан хэллэг болсон байдаг. Үнэндээ эртний урлаг баатарлагийн туульд их хэмжээгээр шингэж, туулийн стилийг бүрдүүлсэн явдал нь онолын талд авч хэлбэл тэр нь бүхий л үндэстний утга зохиолын түүхэн хөгжилтэд зайлшгүй илрэх уламжлал залгамжлалын жам хууль болно, тэрчлэн эдгээр балар урлаг зөвхөн баатарлаг туулийн хөгжилт төдийгүй, бусад урлагийн хэлбэрт хүртэл хөрс шороо болж, шим тэжээл хүртээн тун их нөлөө үйлдэл үзүүлсэн билээ. Гэтэл эцсийн эцэст хааш л хөрс шороо шим тэжээл төдий болохоос биш жинхэнэ үр төмс, яс чөмгийг нь харин омтгойлогсоор ирсэн байна. Иймээс бид баатарлаг туулийн эх үүслийг эрхбиш түүний жинхэнэ уг сурвалж эх үүслээс эхэлж өгүүлэх хэрэгтэй. Харин түүний бүрэлдлийн гуравдугаар шат үетэй хутгалдуулан яриад байвал жинхэнэ уг сурвалж эх үүслийн түүхэн явцыг бүр үгүйсгэхэд хүрнэ. Тэгэхлээр тус тусад нь салгаж ярих нь зүйтэй мэт [1, с. 35].

Ерөнхийд нь үзвэл эртний балар урлаг баатарлаг тууль (шүлэглэсэн хэлбэрийн)-д ийм хэдэн талын нөлөө үйлдлийг үзүүлжээ. Нэгд, эртний шидэт үлгэр нь баатарлаг туулийн баатруудын мах цус амь насыг улгажээ. Хоёрт, эртний домог яриа нь баатарлаг туулийн үлгэр үйл явдлыг цаашид баяжуулан хөгжүүлжээ. Гуравт, ерөөл магтаал, дуу шүлэг нь баатарлаг туулийн хэлбэрийг бүрэлдүүлжээ. Дөрөвт, эртний дуудлага уншлага нь баатарлаг туулийн хайлах урлаг (туулийн хөг аяс гэх мэт)-ийн хэв намбыг тогтоов. Баатарлаг тууль нь эртний аль олон балар урлагийн шинжийг их хэмжээгээр хадгалж байдаг нь эдгээр балар урлагаар бүрэлдсэний үр дүн болно.

Бид баатарлаг туулийн эх үүслийг түүх- түүхт домог (баатрын уламжлал яриа) – баатарлаг туулийн бүрэлдэл гэж үзсэн нь тун харьцангуй билээ. Зарим баатарлаг тууль нь бусад баатар буюу бусад олон зүйлийн урлагийн хэлбэрээ хэсэг бусад үйл явдлын нийлбэр цогцолбороор бүрэлдэн үүссэн байх юм. Гэтэл иймэрхүү баатарлаг тууль нь хожмын үед сая буй болжээ. Жинхэнэ баатарлаг тууль бол бүр үнэн бодитой түүхт хэрэг явдлыг дээр суурилж үүссэн байдаг.

Монгол ардын баатарлаг тууль бол монгол угсаатны онцлог, тэдний аж төрөх ёсны тусгал болж, эрх чөлөө тусгаар тогтнолынхоо төлөө явуулсан тэмцлийн явцад үүдэн бүтээгдэж тархан дэлгэрчээ. Энэ чанараараа монголын нийгэмийн хөгжилд, тэр дундаа цэрэг дайны үйл хэрэгтэй уялдан туульсын агуулга хэлбэр, сэдэв улам бүр өргөжин хөгжиж ирсэн байна. Академич Б. Я. Владимирцов түүхийн сурвалж бичгийг үндэслэн «XIII, XIV зууны үеийн монголчууд чухам туульс бүтээх үед амьдарч байжээ гэж дүгнэж болно. Азийн бусад нүүдэлчин, гөрөөчидийн дунд дэлгэрч байсны адил монголчуудын дунд дэлгэрч байсан туульсын са-

наа, туульсын сэдэв нь XII зууны эцэс XIII зууны эхэнд ер бусын тодорхой нарийн хэлбэрийг олоод том том туульс, дуу, домог үлгэрт магадгүй дэлгэрэнгүй туульсыг буй болгосон байж болно. Зөвхөн их аян дайн хийж өргөн их газар орныг байлдан дагуулснаар барахгүй, тэрхүү олон дайн байлдаан хийгээд дайчин алдар тэргүүтэн нь туульсын сэдвийг хөгжүүлэхэд зохистой нөхцөлийг буй болгожээ» [2, с. 31] гэсэн дүгнэлт бол үнэхээр онож хэлсэн санаа аж.

Бид баатарлаг туульсийн үүссэн цаг үеийг тодлохдоо юуны өмнө түүнд загваршин тогтсон тухайн үеийн нийгэм түүхийн нөхцөлөөс шалтгаалагдсан соёл сэтгэц зүйн бүтэц онцлогийг хайн шинжих хэрэгтэй. Туульс бол аливаа уран зохиолын ерөнхийлөл болсны хувьд үүсэл бүрэлдэл, хөгжлийн явцдаа цагийн судалгаа ихтэй. Хөгжлийн шатандаа адил бус хувиралттай. Яг ийм учраас түүхэн цаг үеийг зааглагч болсон туульсийн язгуур хэв, хожмын хүмүүсийн соёл сэтгэцийн нийтгэл болон үргэлжлэхдээ нэгэнтээгүүр урлагийн сэтгэхүйн анхан төрхөө үргэлжлэн хадгалж, нөгөөтэйгүүр туулсан түүхэн үеийн шинэ нөлөөг адил бус хэмжээгээр хүлээн авсаар ирсэн юм. Сүүлийн үеийн нөлөөгөөр анхны үүсвэрийг орлуулж болохгүйтэй адилхан, анхан төрхөөр ч сүүлийн хувиралтыг үгүйсгэж үл болно. Тогтонгуй хэв загвар болон хөдлөнгө үйл явдлын хоорондох зөрчил бол туульсын хөгжлийн бүх явцад илэрдэг үзэгдэл болжээ. Баатарлаг туулийн иймэрхүү будлиант хувирангуй байдал болон хоёрдмол шинж түүний үүслийн тухай элдэв маргааныг тасралтгүй өдөөн өрнүүлсээр ирж билээ [3, с. 45–46].

Том баатарлаг тууль «Жангар» бол монголын эртний домог ба балар эртнээс уламжилж ирсэн богино хэлбэрийн туулийн сэдэв материалыг ашиглаж зохиосон нь мэдэгдэж буй. Иймээс тус туулийн үүссэн цаг үеийг нягтлахад наад захдаа гурван зүйлийн цаг үеийн тухай ухагдахууныг тодорхой ялгах хэрэгтэй. Даруй энэ тууль лугаа холбогдол бүхий балар эртний домгийн анх үүссэн цаг үе, тус туульд ашиглагдсан богино хэлбэрийн тууль үүссэн цаг үе хийгээд том баатарлаг тууль «Жангар»-ын бүрэлдэн тогтсон цаг үе болно. Энэ гурван цаг үе нь хоорондоо холбоотой мөртлөө бас ялгаатай юм. Тэдгээрийг хутгалдуулж нэгээр нөгөөг орлуулж яасан ч болохгүй [4, с. 2]. Эдгээр гурван цаг үеийн агуулгын дотроос туулийн бүрэлдэн тогтсон цаг үед байсан зүйл нь сая бидний тавьсан асуудлыг нотлоход хэрэгцээтэй зүйл болно. «Жангар»-ын дотор үндсэн зүйл ба дагалдах зүйл, гол чөмөг болсон зүйл ба эргэн тойрны зүйл, мөн чанарыг итгэсэн зүйл ба гадаад үзэгдэл төдий зүйл гэх мэтийн ялгаатай байдаг. Эдгээр нь хувирамтгай чанартай, хөдөлгөөнтэй элемент мөн. Нөгөө үндсэн зүйл, гол чөмөг болсон ба мөн чанарыг илтгэсэн зүйл бол туулийн хувь заяаг шийдвэрлэх хэсэг мөн. Тэдгээр нь туулийн

эхэлж бүрэлдэн тогтох үед байсан бөгөөд тогтонгуй чанартай, хувьсаж өөрчлөгдөхөд бэрхтэй байдаг. Туулийн агуулгын голчөмөг болсон үндсэн зүйл нь түүний сэдэв, үйл явдлын гол шугам, үзэл санаа ба баатрын дүрийн уг дүрсийг харуулж чаддаг. Энэ бол бидний эрж байгаа зүйл мөн. Бид туулийн агуулгын гол чөмөг болсон зүйлийг олбол сая түүнээр дамжиж үүсэн бүрэлдсэн цаг үеийг нь тогтоож болно [5, с. 180–181].

Жинхэнэ баатарлаг тууль нь үндэстэн угсаатныхаа язгуур зориг санаа, үзэл ухамсрыг гүйцэд илэрхийлж, уриалан дуудаж байдаг. Аугаа их зориг, хүч чадал, ухаан билгийн дуулал болсон баатарлаг туулийг хайлан хэлэх явцад сонсогчдын нэг хэсэг нь туульчийн авьяас билгийг бахдан биширч түүн шиг чадварлаг туульч болох хүсэл мөрөөдөлтэй болдог бол, туулийн баатруудын ер бусын их хүч чадал, эр зориг, авхаалж самбаа, адал явдал нь сонсогчдын сэтгэл санааг хөгжөөн баясгаж, баатрыг ялахад нь баярлаж, ялагдахад нь өр өвдөн харамсаж, гунихад нь уйлж, баярлахад нь инээх зэргээр дотоод сэтгэлээрээ туулийн үйл явдалд оролцон, бие сэтгэхүйгээ туульдаа уусган шингээж, хөтлөгдөн жолоодогдож, туулийн баатрууд шиг шилдэг эрс болох гэсэн хүсэл мөрөөдлийн далавч жигүүрийг ургуулан төрүүлдэг аж. Үр хүүхэд ач нар хойчсынхоо ямар ч хүчир бэрхшээлд тулгаран тохиолдоход хүсэл мөрөөдөл, зориг ухамсрыг нь мохоохгүй, амьдралд нь итгэл зориглохын төлөө ямар ямар баатрууд дахин эргэж төрнө, тэр цаг ирнэ гэдэг санааг туульчлан хэлдэг нь маш чухал учир зорилготой. Ингэж үндэстэн угсаатныхаа язгуур зориг санаа, цог сүлд, үзэл ухамсрыг уриалан дуудаж, даллан сэргээдэг нь жинхэнэ баатарлаг туулийн оюун сүнс нь юм. Иймээс ч эртний монголчууд баатрыг эрхэмлэн үзэж, сургаал үлгэр болгож, баатар явсан хүмүүсийн тухай домоглон ярьж, ямар хүн, ямар нөхцөлд яаж баатар болдог тухай хүүхэд, дүү нартаа сургадаг, үүний үр дүнд баатрыг дууриан явах хүсэл мөрөөдөл маш хүчтэй түгээмэл үзэгдэл болж байсан бөгөөд монголчуудын дотор цэргийн баатар хүн олноор төрөн гардгийн учир үүнтэй холбогдох буюу. Туульсын баатар шиг ер бусын баатар болох гэсэн хүсэл мөрөөдөлдөө хөтлөгдсөн монгол хүүхэд бүр гурав дөрвөн наснаасаа морь сайн унаж сурах бөгөөд өөртөө тохирсон нум сумтай болж, харвах намнах дасгал сургууль хийж бүр чадамгай харваач болж арван гурван нас хүрвээс гарын оновчоо тогтооно. Монголчуудын хоорондоо ярилцах ярианд нум сум яаж сайн харвах, ан авлах ба цэрэг дайны явдлыг гол болгох тул бяцхан хөвгүүд нум сумаар яаж харвах ба ан гөрөөс хэрхэн намнахыг цаг бүр хэлж зааж сургана. Ямар овог аймгийн хэн гэгч хөвгүүн яаж харвадаг тухай, тийм зайн газраас тэгж ингэж харваад тийм амьтныг алжээ, тийм дайсныг дарж гэх мэтээр нум сум гойд сайн харвадаг хүмүүсийг алдаршуулан ярина [6, с. 101–102]. Ийнхүү эр зориг дайчин баатарлаг

чанар монголчуудын хувьд багаасаа боловсрон бэлтгэгдсэн «эрт цагийн монгол эрс цөмөөрөө дуртай цэрэг болох тул, эртний монгол цэрэг сайн хэмээн нэр гарсан учир ийм шалтгаантай» байдаг аж [6, с. 219–220].

Баатарлаг тууль нь энэ мэтээр үндэстэн угсаатны дунд эх оронч үзэл, баатарлаг үзэл ба ёс суртахууны хүмүүжлийг төлөвшүүлэхэд хүчтэй нөлөөлөөд зогсохгүй, цэрэг эрсийг эх орон, эрх чөлөөнийхөө төлөө аян дайнд уриалан дуудаж, дайн тулалдаанд хүнд бэрхийг зоригтой даван туулж, дайснаа дарах сэтгэл зүйн бэлтгэлийг нь зарим талаар хангаж өгдөг байсан зэрэг нийгэм ахуйн үйлдэл хэрэгцээ нь баатарлаг туулийн зохиогдон уламжлагдах чухал нэг нөхцөл шалтгаан болсон ажээ.

ЛИТЕРАТУРА

1. Тогтуун. Баатарлаг туульсын үнэн бодит түүхэн шинж // Өвөр монголын багшийн их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл. 1987. № 4.
2. Монгол ардын баатарлагийн туульсын учир. Загдсүрэнгийн эмхэтгэсэн. Улаан Баатар, 1966.
3. Бүрэнбэх Б. Бааталаг үзлийн яруу найраг-баатарлаг туульс // Өвөр монголын их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл. 1989. № 4.
4. Ринчендорж Ж. «Жангар»-ын туульсын үүссэн цаг үеийн тухай дахин өгүүлэх нь // «Жангар»-ын тухай өгүүлэх нь (5 өгүүллийн түүвэр). Шинжааны ардын хэвлэлийн хороо, 1995.
5. Ринчендорж Ж. «Жангар»-ын үүссэн цаг үеийн тухай // «Жангар»-ын тухай өгүүлэх нь (3 өгүүллийн түүвэр). Шинжааны ардын хэвлэлийн хороо, 1995.
6. Лувсанчойдон. Монгол зан аалийн үйлдвэр. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1981.